

# 2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

НТАГ-2020/576/СТА-ТШЗ  
НИЙСЛЭЛИЙН СОЁЛ УРЛАГИЙН ГАЗАР- 2019



# ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.02.21 № 37  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН  
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ,  
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ  
Ч.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2019 оны  
санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан,  
эрчилгээг хүргүүлж байна.

Хавсралт: 31 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.МОНХ-ОЧИР



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: НТАГ-2020/576/СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2020 он	"Эф Эл Эй Эс Эйч Аудит" ХХК-ийн Захирал: Ж.Оргонцэцэг Утас: 99138333 Цахим хаяг: flashaudit1@gmail.com "Эф Эл Эй Эйч Аудит" ХХК-ийн Аудитор: Ж.Оргонцэцэг Утас: 99138333 Цахим хаяг: flashaudit3@gmail.com
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

НТАГ	Нийслэл дэх Төрийн Аудитын Газар
НИТХ	Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал
БЗД	Баянзүрх дүүрэг
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ХУД	Хан-Уул дүүрэг
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Няглан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн Шууд захирагч
ТБОНӨХБАҮХА	Төрийн Болон Орон Нутгийн Өмчийн Хөрөнгөөр Бараа Ажил Үйлчилгээ Худалдан Авах
ДБЭТ	Дуурь Бүжгийн Эрдмийн Театр
МБХС	Монголын Балет Хөгжлийн Сан
НСҮГ	Нийслэлийн соёл, урлагийн газар
ХХОАТ	Хувь Хүний Орлогын Албан Татвар
АТБӨЯХАТ	Авто Тээвэр Болон Өөрөө Явагч Хэрэгслийн Албан Татвар

**Агуулга**

<b>1. Аудитын гэрчилгээ</b>	3
<b>2. Аудитын тайлан</b>	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох буртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	7
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	9
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	9
<b>3. Менежментийн захидал</b>	12
<b>4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан</b>	15
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	15
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	17
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	19
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	21
4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	22
4.6 Аудит хийгдсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	23
<b>5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт</b>	24



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.city.audit.mn

2020.02.21 № 378  
таний -ны № -т

НИЙСЛЭЛИЙН СОЁЛ, УРЛАГИЙН  
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ, ТӨСВИЙН ШУУД  
ЗАХИРАГЧ Ч.БАТ-ЭРДЭНЭ  
ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 дахь заалтад заасны дагуу Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон

удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бурдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### **Аудитын гол асуудал**

Хөтөлбөр арга хэмжээг зохион байгуулахад оролцсон иргэдэд олгосон ажлын хөлснөөс нийгмийн даатгалын шимтгэлийн 9,941.5 мянган төгрөгийг суутгаагүй, татвар болон ажлын хөлсийг нийт 4,760.1 мянган төгрөгөөр зэрүүтэй тооцсон, үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 24,000.0 мянган төгрөгийн хөрөнгө биетээр байхгүй байгаа зэрэг зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн оршин байх, тохиолдсон байх, үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бodoх бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТМР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ  Б.МОНХ-ОЧИР

## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Бат-Эрдэнэд танилцуулж байна.

Энэхүү тайландаа үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд НТАГ-тай байгуулсан гурвалсан гэрээг үндэслэн аудит хийлгээ.

Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Эф Эл Эй Эс Эйч Аудит” ХХК-ийн аудитор Ж.Отгонцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Эф Эл Эй Эс Эйч Аудит” ХХК-д 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01/37 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас

санхүүгийн тайланда аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах өрөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалыар баталгаажуулсан болно.

#### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Нийслэлийн Соёл, урлагийн газрын үйл ажиллагааны эрхэм зорилго нь нийслэлийн хүн амд үзүүлэх соёлын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, гоо зүй болон уран сайхны боловсрол, мэдрэмжийг дээшлүүлэх, соёл урлагийг хөгжүүлэх, соёлын үнэт зүйлсийг өвлүүлэн эзэмшигүүлэх, соёлын олон талт үйл ажиллагааг жигд чанартай зохион явуулахад оршино.

Нийслэлийн Соёл, урлагийн газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: Соёл, урлагийн талаарх зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх ажлыг мэргэжил, арга зүйн дээд төвшинд удирдан зохион байгуулах, НИТХ. Засаг даргыг соёл урлагийн мэргэжлийн өндөр төвшинд цаг үеэ олсон эцсийн шатны бодлого, зөвлөмжөөр шуурхай ханганд, нийслэлийн хүн амын соёлын төвшин болон хариуцсан салбарынхаа ажлын үр дүн, үр нөлөөг дээшлүүлэн ажиллахад чиглэнэ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй байна.

#### **2.5. Нягтлан бodoх бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дotoод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланда материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бodoх бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дotoод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бodoх бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бodoх бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцгүй байна. Тухайлбал: Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан НХМаягт ТМ-5 төлбөрийн баримтын талаар оруулаагүй, тухайн байгууллагын онцлог ажил гүйлгээ, хуулийн заалтуудыг тодорхой оруулж өгөөгүй байна.

Нийслэлийн Соёл, урлагийн газар нь санхүү, нягтлан бodoх бүртгэлийн үйл ажиллагаанд "ACOLOUS" программ хангамж ашигладаг байна.

Нийслэлийн Соёл, урлагийн газрын дotoод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дotoод хяналт үр нөлөөгүй байна.

#### **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитаар Нийслэлийн Соёл, урлагийн газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дotoод орчин, дotoод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 28 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

## 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны III улирлын санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,002,655.5 мянган төгрөгөөс тооцон 10,026.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 20,981.5 мянган төгрөгөөр тооцсон нь жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн нийт зардал төлөвлөлтийн үе шатанд тооцсон дүнгээс 1,095,493.7 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой.

## 2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Нийслэлийн соёл урлагийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 122,792.52 мянган төгрөгөөр буюу 25.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, урьдчилгаа, үндсэн хөрөнгийн дансуудтай холбоотой байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
				3=2-1
Б	1	2		
Мөнгөн хөрөнгө	2,384.90	16,602.02	14,217.12	
Авлага	977.55	-	(977.55)	
Урьдчилгаа	4,704.00	34,704.00	30,000.00	
Бараа материал	439,737.17	408,375.48	(31,361.69)	
Үндсэн хөрөнгө	30,929.12	141,843.78	110,914.65	
Нийт хөрөнгө	478,732.74	601,525.27	122,792.49	
Өр төлбөр	2,824.73	16,602.02	13,777.29	
Засгийн газрын оролцоо/Эздийн өмч/	475,908.01	584,923.26	109,015.24	
Нийт өр төлбөр ба цэвэр өмчийн дүн	478,732.74	601,525.27	122,792.49	

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь ХУД, БЗД, СХД-үүдийн Соёлын ордонд жишиг номын сан байгуулахад шаардлагатай тавилга, тоног төхөөрөмж, номын баяжуулалтын хөрөнгө оруулалтын зардалд захиалагчийн хяналт тавьж, гүйцэтгэлийн баталгаа болох 16,602.02 мянган төгрөгийг байршуулсантай холбоотой нэмэгдсэн.

Урьдчилгаа 30,000.0 мянган төгрөгөөр өссөн нь “Цэвэр агаартай хот” арга хэмжээг зохион байгуулах гэрээ нь 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөр

дуусгавар болох тул урьдчилж гарсан зардал дансанд 30,000.0 мянган төгрөгөөр бүртгэсэнтэй холбоотой үүссэн.

Бараа материалын дансны үлдэгдэл 31,361.69 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 37,040.58 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 35,545.28 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан. Мөн тайлант онд 32,856.99 мянган төгрөгийн бараа материалыг Нийслэлийн Соёл, урлагийн газрын даргын 2019 оны А/13 тоот тушаалаар акталсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 110,914.65 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд Нийслэлийн Өмчийн харилцааны газрын 2018 оны 3/1496 тогтоол шийдвэрийн дагуу шөнийн гэрэлт гудамжны 153,100.0 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, Нийслэлийн Соёл, урлагийн байгууллагуудын нэгдсэн мэдээллийн цахим хуудсыг бүтээхэд 15,000.0 мянган төгрөг зарцуулсныг бусад үндсэн хөрөнгөөр, Улаанбаатар чуулгаас шилжиж ирсэн 1,051.6 мянган төгрөгийн үнэ бүхий ширээг бүртгэн авсантай холбоотой. Мөн тайлант хугацаанд Нийслэлийн өмчийн харилцааны газрын зөвшөөрөлтэйгөөр харьяа соёлын орднуудад балансаас балансад нийт 4,530.4 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн. 7,678.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан. Тайлант хугацаанд 57,336.7 мянган төгрөгийн байгуулсан элэгдлээр, шилжүүлсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 12,141.1 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийн бууралт үүссэн. Тайлант хугацаанд балансаас балансад шилжиж ирсэн үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 832.5 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгийн дүн өссөн.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2018, 2019 онуудын 16,602.0 мянган төгрөгийн барьцаа хөрөнгө эзэлж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 601,525.27 мянган төгрөг болж 109,015.24 мянган төгрөгөөр өссөн нь нийт үр дүнгийн өсөлтөөс шалтгаалжээ.

## 2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 246,830.8 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 246,830.8 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 246,830.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Хөрөнгө оруулалтын 1 төсөл, арга хэмжээнд 284,342.3 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 284,342.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 239,419.9 мянган төгрөг буюу 97 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 3,944.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжаас хэмнэсэн зардал нь 3,288.1 мянга, бараа ажил үйлчилгээний

зардлаас 178.5 мянга, нийт 7,410.3 мянган төгрөгөөр дутуу зарцуулнаас шалтгаалжээ.

**Нэмэлт төсөв:** Нийслэлийн ЗД-ын захирамжийн дагуу ЗДТГ-аас нийт 1,522,672.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлжээ. Үүнээс нийслэлийн хэмжээнд зохион байгуулсан соёл, урлаг болон бусад арга хэмжээнд зарцуулжээ.

## 2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 28 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 28 эрсдэл тодорхойлж, нийт 9 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар илэрсэн 38,767.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

## 2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Нийслэлийн соёл, урлагийн газар, Соёлын төв өргөө, Монголын балетын хөгжил сангийн хамтран ажиллах 2014 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн №4 тоот турвалсан гэрээнд 2014 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн нэмэлт өөрчлөлт оруулсан заалтын дагуу Нийслэлийн соёл, урлагийн газар нь “Цөмөөхэй” балетын нийт 563 ширхэг 401,693.0 мянган төгрөгийн хувцас, тайзны эд хэрэглэлийг бараа материалын дансанд бүртгэн авсан боловч хадгалалт хамгаалалт, ашиглалтыг МБХС, бүртгэлийг НСҮГ хариуцан ажиллаж байна.

Нийслэлийн засаг даргын захирамжийн дагуу хийгдэж байгаа ажил, арга хэмжээг зохион байгуулахдаа ТБОНӨБАҮХА тухай хуулийн 32 дугаар зүйлийг хэрэгжүүлээгүй. Эдгээр асуудлуудыг 2020 оны завсрын аудитаар үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 2.13. Шилэн дансны мэдээлэл

Нийслэлийн Соёл, урлагийн газар нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 2 мэдээллийг байршуулаагүй байна.

## 2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 426,542.0 мянган төгрөгийн зөвлөмж хүргүүлснээс 402,542.0 мянган төгрөгийн зөвлөмжид тодорхой арга хэмжээг авч ажилласан байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмжийг шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллаж байгаа боловч тодорхой үр дүн гаррагүй байна.

## 2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Нийслэлийн Соёл урлагийн газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайландаа аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

"Хязгаарлалттай" дүгнэлт

Нийслэлийн Соёл урлагийн газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн залруулагдаагүй буруу илэрхийллийн санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөөг эс тооцвол 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Няглан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.3 заалтын дагуу үнэн зөв илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
СОЁЛ, УРЛАГИЙН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
8 дугаар хороо, Бага тойруу-1, Амарын гудамж 2,

Соёлын төв өргөө

Утас: 32-15-29, Факс: (976-11) 32-45-37

<http://www.nsug.ub.gov.mn>

E-mail: [info@nsug.ub.gov.mn](mailto:info@nsug.ub.gov.mn)

2020.02.19 № 01/60

таяй -ны № -т

ФЛАШ АУДИТ ХХК-Д

Тус газрын 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн асуудлын бүртгэлтэй танилцлаа.

Энэхүү аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг хүлээн зөвшөөрч байна.



E:\2020 он\Албан бичиг A-5.docx

### 3.Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидалыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидалын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайландаа тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайландаа шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

##### 1.1 Илрүүлэлт:

- Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 24,000.0 мянган төгрөгийн грашийн барилга нь газрын маргаантай байдлаас нураагдаж биетээр байхгүй байхад данс бүртгэлээс хасалт хийгээгүй. Энэ нь санхүүгийн тайлангийн бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. "үнэн зөв байх" заалтыг зөрчсөн.

##### 1.2 Эрсдэл:

- Биет хөрөнгө дутагдаж, ашиглан үүсэх

##### 1.3 Зөвлөмж:

- Хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг сайжруулж, биет байхгүй хөрөнгийн асуудлыг эрх бүхий байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлэх.

##### 1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар

- 01/60 тоот албан бичгээр тайлбар өгч, зөвшөөрсөн.

#### 2. Дотоод хяналттай холбоотой асуудал

##### 2.1 Илрүүлэлт:

- Тус байгууллагын дарга хоёр удаа солигдсон ба даргын үүрэг гүйцэтгэгчээр томилогдон ажиллахдаа үр дүнгийн гэрээ байгуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5 дахь заалтыг зөрчж байна.

2.2 Эрсдэл:

- Дотоод хяналт сулрах, сахилга бат алдагдах

2.3 Өгсөн зөвлөмж:

- Үр дүнгийн гэрээ байгуулж, төсвийн тухай хуулийн 16.5 дахь заалтыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэв.

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

- 01/60 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн.

**3. Хөтөлбөр, арга хэмжээтэй холбоотой асуудал**

3.1 Илрүүлэлт:

- Нийслэлийн засаг даргын А/1080 тоот захирамжийн хүрээнд хөтөлбөр, арга хэмжээг зохион байгуулахдаа уран бүтээлчид болон дуучидтай гэрээ байгуулж ажиллаагүй. Тухайн арга хэмжээнд оролцсон уран бүтээлчид, дуучдын төлбөрийг олгоходо нийгмийн даатгалын шимтгэлийн 9,941.5 мянган төгрөгийг суутгаагүй. Энэ нь үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Иргэний хуулийн 343, 359 дүгээр заалтуудыг зөрчиж байна.
- Дээрхи Нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооллын алдааны улмаас ХХОАТ-ыг 1,140.7 мянган төгрөгийн зөрүүтэй тайлагнасан, ажлын хөлсийг 3,619.4 мянган төгрөгийн зөрүүтэй олгосон. Энэ нь үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйл, ХХОАТ-н тухай хуулийн 23.2.2 дугаар заалтыг зөрчиж байна.

3.2 Эрсдэл:

- Нийгмийн даатгал болон ХХОАТ-н хуулийн хүрээнд торгууль, алданги тооцуулах эрсдэлтэй.

3.3 Өгсөн зөвлөмж:

- Хөтөлбөр арга хэмжээнд оролцогч иргэдтэй гэрээ байгуулж ажиллах, НД-н тухай хуулийн 4 дүгээр зүйл, ХХОАТ-ын тухай хуулийн 23.2.2 дугаар заалтыг мөрдөж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэв.

3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

- 01/60 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн.

**4. Бусад татвартай холбоотой асуудал**

4.1 Илрүүлэлт:

- Татварын албанаас нэхэмжилсэн АТӨЯХАТ болох 65.5 мянган төгрөгийг бүртгэлд тусгаагүй. Энэ нь эрх ба үүрэг, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүйгээс гадна АТӨЯХАТ-н тухай хуулийн 7.2 дугаар заалтыг зөрчиж байна.

4.2 Эрсдэл:

4.3 Өгсөн зөвлөмж:

Татварын албанаас нэхэмжилсэн аливаа өрийн үлдэгдэлд тухай бүр тооцоо нийлж хуулийн хугацаанд төлбөр тооцоог барагдуулж байх талаар зөвлөмж хүргүүлэв.

4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

- 01/60 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн.

## 5. Санхүүгийн программтай холбоотой асуудал

### 5.1 Илрүүлэлт:

- Программ дээр нийтлэг гарч буй алдаа нь цалингийн цэстэй холбоотойгоор байгууллагад өгөх өглөг данс нь харилцагч сонгох боломжгүй байдагтай холбоотойгоор дансны харьцаа буруу бичигдэж байна. Энэ нь үнэн зөв байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна НББ тухай хуулийн 14.2 дах заалтыг зөрчиж байна.

### 5.2 Эрсдэл:

- Нэг төрлийн данс хоорондоо харьцах стандарт бус бичилт үүсэх эрсдэлтэй.

### 5.3 Өгсөн зөвлөмж:

- Программ хангамжийн газрын программ нэвтрүүлэлтийн ажилтангаас зөвлөгөө авч ажиллах

### 5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

- 01/60 тоот албан бичгээр хариу хүргүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Нийслэл дэхь төрийн аудитын байгууллагад 2020 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

### Аудитын тайланг

#### Тайлан бэлтгэсэн:

Эф Эл Эй Эс Эйч Аудит ХХК-ийн аудитор:

/Ж.Отгонцэцэг/



#### Хянасан:

Санхүүгийн аудитын хэлтсийн дарга

/Ц.Бат-Өлзий/

бөгөөд аудитын менежер:

/А.Цогбаяр/

Аудитын менежер:

**4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан**

**4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан  
/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>447,803,621.00</b>	<b>459,681,496.14</b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	2,384,900.00	16,602,016.14
312	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	2,384,900.00	16,602,016.14
3121	<b>Төгрөг</b>	2,384,900.00	16,602,016.14
31211	Төрийн сангийн харилцах	2,384,900.00	16,602,016.14
33	<b>АВЛАГА</b>	977,551.00	00.00
335	<b>Бусад авлага</b>	977,551.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	977,551.00	00.00
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	4,704,000.00	34,704,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	4,704,000.00	34,704,000.00
3471	<b>Урьдчилгаа тооцоо</b>	-	-
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	439,737,170.00	408,375,480.00
351	<b>Түүхий эд материал</b>	29,901,900.00	00.00
35110	Тусгай зориулалттай материал	29,901,900.00	00.00
354	<b>Хангамжийн материал</b>	409,835,270.00	408,375,480.00
35410	Бичиг хэргийн материал	230,000.00	230,000.00
35420	Аж ахуйн материал	6,323,670.00	5,835,480.00
35430	Сэлбэг хэрэгсэл	538,000.00	538,000.00
35440	Түлш, шатах тослох материал	850,000.00	80,000.00
35470	Бусад хангамжийн материал	401,893,600.00	401,692,000.00
2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>30,929,124.04</b>	<b>141,843,776.03</b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	30,929,124.04	141,843,776.03
392	<b>Биет хөрөнгө</b>	30,929,124.04	141,843,776.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	24,000,000.00	24,000,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-13,200,000.00	-13,200,000.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	10,000,000.00	10,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-10,000,000.00	-10,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	240,115,634.10	384,013,400.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-228,566,946.62	-274,448,895.84
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,996,560.70	25,038,099.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,188,124.14	-20,542,493.77
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,820,000.00	19,823,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,048,000.00	-2,839,833.36
3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>478,732,745.04</b>	<b>601,525,272.17</b>
4	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,824,729.20</b>	<b>16,602,016.14</b>
